



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 01369

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн “Тээвэрлэлт
үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын данс
бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/821 дүгээр захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэгдсэн 23,328,000.0 /хорин гурван сая гурван зуун хорин найман мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Донг Фенг маркийн 21-16 УНБ улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Сонгинохайрхан дүүргийн “Тээвэрлэлт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ /С.Мөнхбат/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг сэлбэгийн зориулалтаар фондолж, ашиглалтын шаардлага хангахгүй болон илүүдэлтэй сэлбэгүүдийг хоёрдогч түүхий эд, сэлбэгийн зориулалтаар 500,000.0 /таван зуун мянган/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан борлуулж зохих дансанд нь орлого болгон авахыг Сонгинохайрхан дүүргийн “Тээвэрлэлт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ /С.Мөнхбат/-т үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Сонгинохайрхан дүүргийн “Тээвэрлэлт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ /С.Мөнхбат/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /М.Мандах/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮНЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ҮНЭНБАТ

1119282495 2576589

115050000909